ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв"ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/11/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70378845<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Аудитор: Ч.Гантулга<br>Утас: 99372297<br>Цахим хаяг: tsesb.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .......... 2
Асуудлыг онцолсон хэсэг .......... 3
Аудитын гол асуудал .......... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .......... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .......... 10
4. АУДИТЫН ТАЙЛАН .......... 12
4.1 Ерөнхий зүйл .......... 12
4.2 Материаллаг байдал .......... 12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 13
4.4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .......... 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 13
4.5.1 Завсрын аудитын талаар .......... 13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... 14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОНӨ | Орон нутгийн өмч |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УОО | Урьдчилж орсон орлого |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 182

танай ______________-ны №______________ -т

"ХӨДӨӨ АЖ АХУЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ДУНДЫН ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН МЕНЕЖЕР
Т.АМГАЛАНБААТАР ТАНАА

**Хязгаарлалтай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, тодруулгуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байгууллагын мөнгөн хөрөнгийн харилцах дансаар 48,640.2 мянган төгрөгийн 78 зарлагын гүйлгээ 1 дүгээр гарын үсэггүйгээр гүйцэтгэсэн нь бидний тогтоосон 1,220.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана......."Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4526050307

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын шийдвэрээр 229,359.7 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмжийг Орхон сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлснийг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын удирдах албан тушаалтныг 2025 онд томилж албан үүргийг хэрэгжүүлээгүйгээс үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

**Бусад асуудал**

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **132,096,535.49** | **256,298,818.34** |
| **2** | **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **121,211,998.36** | **238,662,418.22** |
| 3 | 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 121,211,998.36 | 17,330,001.95 |
| **6** | **33** | **АВЛАГА** | **10,841,194.13** | **17,602,950.74** |
| 7 | 33100 | Татвар, НДШ-ийн авлага | 211,194.13 | 272,948.79 |
| 8 | 33401 | Дансны авлага /Т ӨҮГ/ | 10,630,000.00 | 17,330,001.95 |
| **9** | **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **43,343.00** | **33,449.38** |
| 10 | 35400 | Хангамжийн материал | 43,343.00 | 33,449.38 |
| **17** | **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **324,681,544.76** | **95,321,832.38** |
| **18** | **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **324,681,544.76** | **95,321,832.38** |
| 19 | 39200 | Үндсэн хөрөнгө | 268,427,944.76 | 39,636,192.38 |
| 31 | 39300 | Биет бус хөрөнгө | 56,253,600.00 | 55,685,640.00 |
| **34** | **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **456,778,080.25** | **351,620,650.72** |
| **35** | **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **88,738,028.55** | **237,354,385.02** |
| **36** | **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **88,738,028.55** | **237,354,385.02** |
| 37 | 41300 | Өглөг | 88,738,028.55 | 236,600,021.92 |
| 38 | 41360 | Бусад өглөг | - | 754,363.10 |
| **40** | **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **368,040,051.70** | **114,266,265.70** |
| **41** | **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **368,040,051.70** | **114,266,265.70** |
| 42 | 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /Т ӨҮГ/ | **409,207,600.00** | **208,730,436.91** |
| 43 | 51200 | Хуримтлагдсан үр дүн | (41,167,548.30) | (94,464,171.21) |
| 44 | 51210 | Өмнөх үеийн үр дүн | (36,731,120.12) | (41,167,548.30) |
| 45 | 51220 | Тайлант үеийн үр дүн | (4,436,428.18) | (53,296,622.92) |
| **46** | **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **456,778,080.25** | **351,620,650.72** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| 1 | I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **46,900,000.00** | **18,850,000.00** |
| 2 | 12 | **БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО** | **46,900,000.00** | **18,850,000.00** |
| 3 | 120 | **Борлуулалтын өртөг** | - | - |
| 4 | 120009 | Нийт ашиг | 46,900,000.00 | 18,850,000.00 |
| 5 | 120010 | Бусад орлого | 70,898,432.04 | 5,893,590.00 |
| 7 | 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /Т ӨҮГ/ | 122,069,860.22 | 77,600,212.92 |
| 8 | 210813 | Бусад зардал /Т ӨҮГ/ | 165,000.00 | 440,000.00 |
| 9 | III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)- (II)** | **(4,436,428.18)** | **(53,296,622.92)** |
| 10 | VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | (4,436,428.18) | (53,296,622.92) |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | Устгалын өмнөх | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 1 | 1 | 2024 оны 12-р сарын 31-н ээрх үлдэгдэл | 409,207,600.00 | - | (41,167,548.30) | 368,040,051.70 |
| 6 | 11 | 2025 оны 1-р сарын 1-н ээрх үлдэгдэл | 409,207,600.00 | - | (41,167,548.30) | 368,040,051.70 |
| 7 | 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | - | (53,296,622.92) | (53,296,622.92) |
| 8 | 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | (200,477,163.09) | | (200,477,163.09) |
| 9 | 19 | Тайлант үеийн үр дүн | | - | | |
| 10 | 20 | 2025 оны 12-р сарын 31-н аарх үлдэгдэл | 409,207,600.00 | (200,477,163.09) | (94,464,171.21) | 114,266,265.70 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| № | Дансны нэр, терөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 2 | Мөнгөн орлогын дүн | 202,530,288.55 | 165,952,383.38 |
| 3 | Бараа борлуулсан үйлчилгээний орлого | 40,050,000.00 | 6,000,000.00 |
| 4 | Татаас санхүүжилтийн орлого | 70,723,080.00 | - |
| 5 | Бусад мөнгөн орлого | 91,757,208.55 | 159,952,383.38 |
| 6 | Мөнгөн зарлагын дүн | (72,152,709.99) | (48,501,963.52) |
| 7 | Ажиллагчид төлсөн мөнгө | (48,075,905.21) | (33,607,687.64) |
| 8 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (12,724,758.93) | (9,818,413.02) |
| 9 | Бараа материал худалдан авахад | (459,014.00) | - |
| 10 | Ашиглалтын зардалд төлсөн | (440,000.00) | (500,000.00) |
| 11 | Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл сэлбэг төлсөн мөнгө | (2,085,000.00) | (583,500.00) |
| 12 | Татварын байгууллагад төлсөн | (5,194,231.85) | (3,002,212.86) |
| 13 | Бусад мөнгөн зарлага | (3,173,800.00) | (990,150.00) |
| 14 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **130,377,578.56** | **117,450,419.86** |
| 15 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 9,350,000.00 | |
| 19 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **121,027,578.56** | **117,450,419.86** |
| 20 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **184,419.80** | **121,211,998.36** |
| 21 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **121,211,998.36** | **238,662,418.22** |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

| д/д | Зардлын нэр | 2025 он | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү | хувь |
| **ОРЛОГО** | | | | | |
| 1 | Үйл ажиллагааны орлого | - | 18,850,000.00 | - | - |
| 2 | Татаас санхүүжилт | - | 5,893,590.00 | - | - |
| | **ОРЛОГЫН ДҮН** | **-** | **24,743,590.00** | **-** | **-** |
| 1 | НИЙТ ЗАРДАЛ | - | - | - | - |
| 2 | Ерөнхий ба удирдлагын зардал | - | 77,600,212.92 | - | - |
| 3 | Бусад зардал | - | 440,000.00 | - | - |
| **БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ** | | **-** | **78,040,212.92** | **-** | **-** |
| **АШИГ, АЛДАГДАЛ** | | **-** | **(53,296,622.92)** | **-** | **-** |

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж нийт 59,770.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 56,920.6 төгрөгийн алдааг залруулж, 2,850.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

"Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-ын дүрмийн 4.2-т "Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралыг аймгийн Засаг дарга, бусад ажилтныг гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө" гэж заасны дагуу гүйцэтгэх захирлыг томилоогүй, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлаагүй, мөн тайлант онд дүрмийн 3.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс үйл ажиллагааны орлого олоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 56.920.6 мянган төгрөгийн алдаа[1] илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Завсрын аудитаар санхүүгийн тайлан дахь үндсэн үйл ажиллагааны орлогын дүн, байдлын тайлангийн авлагын дүн, мөнгөн хөрөнгийн дүнгүүд нийт 56,920.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, _УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул татварын бүртгэлийн тайлангийн алдааг залруулав.

Мөн аудитаар нийт 51,490.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

**5.3 Зөвлөмж**

***5.3.1. Үндсэн үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал***

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

***Илрүүлэлт:***

Тайлант онд хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийн түрээсийн орлого 2,850.0 мянган төгрөгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд орлогод харилцах дансанд төвлөрүүлээгүй байна. Энэ нь Хамтран ажиллах гэрээний заалттай нийцэхгүй байна.

***Зөвлөмж:***

Хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг бүрэн авч байх

***5.3.2. Хөрөнгийн зарцуулалтын хяналттай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:***

Байгууллагын мөнгөн хөрөнгийн харилцах дансаар 48,640.2 мянган төгрөгийн 78 зарлагын гүйлгээг 1 дүгээр гарын үсэггүйгээр шилжүүлсэн, мөн санхүүгийн тайланг газрын менежер гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана.......", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Зөвлөмж:***

Хуульд заасны дагуу байгууллагын санхүүгийн тайлангийн үйл ажиллагааг захирлаар удирдуулах, санхүүгийн тайланг гүйцэтгэх удирдлагаар баталгаажуулж байх

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| санхүүгийн тайлан дахь үндсэн үйл ажиллагааны орлогын дүн, байдлын тайлангийн авлагын дүн, мөнгөн хөрөнгийн дүнгүүд нийт 56,920.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | 56,920.6 | - | - | 1 | 56,920.6 | 1 | 56,920.6 | - | - | - | - |
| **Дүн** | 1 | **56,920.6** | - | - | 1 | **56,920.6** | 1 | **56,920.6** | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд хөдөө аж ахуйн техник тоног төхөөрмжийн түрээсийн орлого болох 2,850.0 мянган төгрөгийн төлбөрийг авч, орлогод төвлөрүүлээгүй байна | 1 | 2,850.0 | - | - | - | - | 1 | 2,850.0 | - | - | - | - |
| Байгууллагын мөнгөн хөрөнгийн харилцах | 1 | 48,640.2 | | | | | 1 | 48,640.2 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| дансаар 48,640.2 мянган төгрөгийн 78 зарлагын гүйлгээ 1 дүгээр гарын үсэггүйгээр гүйцэтгэсэн байна. | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **51,490.0** | - | - | - | - | **2** | **51,490.0** | - | - | - | - |

### ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

**Байгууллагын** "ХАА техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ

**Аудитын код:** ДАА-2026/11/НА-СТА-ОНА

**Тайлант хугац:**2025 он

**Эрсдэлтэй АГАДҮТ-н түвшинд хэрэгжүүлэх түүврийн сорилын үр дүнг үнэлж шийдвэрлэх**

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮТ-н дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур: Стандартын заалт | Шалгуур: Хууль тогтоомжийн заалт | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Ажил гүйлгээний анги | Нийт зардал | Санхүүгийн тайлан дахь үндсэн үйл ажиллагааны орлогын дүн, байдлын тайлангийн авлагын дүн, мөнгөн хөрөнгийн дүнгүүд нийт 56,920.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн | 56,920,609.00 | Үгүй | Үгүй | НББОУС 1, 24 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт | Зөрчил | Залруулга | | | |
| 2 | Ажил гүйлгээний анги | Орлого | Тус байгууллага 2024 онд ХАА техникийн түрээсийн төлбөр иргэн Н.Соёлмаагаас 500.0 мянган төгрөг, Б.Баярсайханаас 2,350.0 мянган төгрөгийн төлбөрийг аваагүй байна. | 2,850,000.00 | Үгүй | Тийм | НББОУС 1, 24 | Хамтран ажиллах гэрээ | Зөрчил | Зөвлөмж | 2025.12.10-нд одор Б.Баярсайхан 2350000 ₮-г авлага барагдуулсан. | | |
| 3 | Ажил гүйлгээний анги | Зардал | Байгууллагын мөнгөн хөрөнгийн харилцах дансаар 48,640.2 мянган төгрөгийн 78 зарлагын гүйлгээ 1 дүгээр гарын үсэггүйгээр гүйцэтгэсэн | 48,640,204.00 | Тийм | Тийм | НББОУС 1, 24 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 13 дугаар зүйлийн 13.4 | Зөрчил | Зөвлөмж | | | |
| | ДҮН | | | 108,410,813.00 | | | | | | | | | |

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:

"Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын дарга ........ Т.Амгаланбаатар Огноо:

Нягтлан бодогч ........ Ш.Урнаа Огноо:

Зөвшөөрөөгүй бол шалтгааныг бичнэ ........

Асуудлын бүртгэл хөтөлсөн: "ЦЭСБ аудит" ХХК-ийн захирал ........ Ч.Цэрэннадмид Огноо:

"ЦЭСБ аудит" ХХК-ийн аудитор ........ Ч.Гантулга Огноо:

Анхан шатны хяналт хийсэн: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор ........ С.Батцэцэг Огноо: 2026.03.13.

Хоёр дахь шатны хяналт хийсэн: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер ........ У.Батсүрэн Огноо: 2026.03.13

Гурав дахь шатны хяналт хийсэн: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор ........ Ш.Мөнхбаяр Огноо: 2026.03.13

ДАРХАН-УУЛ АЙМАГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДЫН ТӨВ 1922...014 ...9289005